



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 04 сарын 17 өдөр

Дугаар 189

Улаанбаатар хот

“Мэдээлэл, холбооны сүлжээ” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийн тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар зүйл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 184 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн захиралтай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх журам”-ын 2.1, 2.3, 3.1, 3.10, 4.3 дахь заалт, Засгийн газрын 2025 оны 137 дугаар тогтоолыг тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Мэдээлэл, холбооны сүлжээ” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон Гүйцэтгэх захирал Б.Мөнхбаттай байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийг “Сайн” гэж дүгнэсүгэй.

2.“Мэдээлэл, холбооны сүлжээ” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Гүйцэтгэх захирал Б.Мөнхбаттай Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ шинэчлэн байгуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд чиглэл болгосугай.

3.“Мэдээлэл, холбооны сүлжээ” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг ханганд биелүүлж, 2024 оны Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлт “Сайн” гэж дүгнэгдсэн гүйцэтгэх захирал Б.Мөнхбатад хавсралтад заасны дагуу урамшуулал олгосугай.

4.Б.Мөнхбатад олгох урамшууллыг холбогдох зардлаас гаргахыг “Мэдээлэл, холбооны сүлжээ” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Санхүүгийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч М.Баярсайханд зөвшөөрсүгэй.

5.Засгийн газрын 2025 оны ““Эрчиж Монгол” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 137 дугаар тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

• 132330724  
9-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлогого зохицуулалтын газрын  
2025.оны 04 дугаар сарын 17.-ны өдрийн  
15.00 дугаар тогтоолын хавсралт

"МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ" ТӨРИЙН ӨМЧИТ ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН ЗАХИРАЛД  
2024 ОНЫ АЖЛЫН ҮР ДҮНГЭР ОЛГОХ УРАМШУУЛАЛ

Д/А	Хуулийн этгээдийн нэр	Захирлын нэр	Цэвэр ашиг	Цэвэр ашигийн дүнгээс хасаж тооцох валютын ханшийн өөрчлөлтөөс олсон ашиг алдагдал	Урамшуулалт тооцох Цэвэр ашиг	Урамшуулалт тооцох Цэвэр ашиг	Олгох урамшууллын хэмжээ
1	"Мэдээлэл холбооны сүлжээ" ТӨХХК	Б.Мөнхбат	1,462,116,459.84	-	1,462,116,459.84	25,292,423.29 (хорин таван сая, хоёр зүүн ерэн хоёр мянга, дөрвөн зуун хорин гурван төгрөг хорин ёсөн мөнгө)	--00o--